



СУРГАЛТ ОЮУТНЫ ХӨГЖИЛ ЭРХЭЛСЭН
ПРОРЕКТОР Д.Д.ЗАЯАБААТАР

2024-2025 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН МУИС-ИЙН ОЮУТНЫ УРЛАГИЙН ИХ НААДМЫН УДИРДАМЖ

Зорилго: Ардын уламжлалт болон орчин үеийн урлагаар дамжуулан оюутан залууст эерэг соёлыг түгээх мөн МУИС-ийн соёл оюутан хоорондын харилцааг бэхжүүлэх, гоо зүйн мэдлэгийг дээшлүүлэх, амралт чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, шинэ уран бүтээлч залуусыг уран бүтээл туурвихад дэмжлэг үзүүлэх, МУИС-ийн урлагийн авьяастай оюутан залуучуудыг шалгаруулж МУИС-ийн оюутны нэгдсэн урлагийн тоглолт зохион байгуулах:

Үр дүн, ач холбогдол:

1. МУИС-ийн оюутны урлагийн баг, хамтлагуудыг бэлтгэх
2. Суралцагчдын урлаг, гоо зүйн боловсролыг дээшлүүлэх
3. Багш, ажилчид, суралцагчдад зориулсан үнэ төлбөргүй урлагийн их наадам шилдэг үзүүлбэрүүдээс бүрдсэн тоглолт зохион байгуулах
4. Нийгмийн хариуцлагын хүрээнд урлагийн их наадмын шилдэг үзүүлбэрүүдээс бүрдсэн тоглолт зохион байгуулах

Хамрах хүрээ: МУИС-ийн бакалаврын түвшний оюутнууд

Хугацаа: 2025 оны 05 дугаар сарын 03-ны 09:00 цагт

Хаана: Цэргийн дуу бүжгийн эрдмийн чуулга I Офицерүүдийн ордон

Зохион байгуулагч: МУИС-ийн Оюутны хөгжлийн газар, ОЗ

Урлагийн их наадмын хөтөлбөр:

№	Хөтөлбөр	Огноо	Цаг
1	Хөтлөгч наадмыг эхлүүлнэ	МУИС-ийн урлагийн их наадмыг эхлүүлэх	09:00
2	Гоцлол эсвэл хоршил хөгжим	Бүх салбар сургууль	09:10
3	Хамтлаг бүжиг /Цэнгээнт/	Бүх салбар сургууль	10:30
4	Завсарлага	Цайны завсарлага	12:50
5	Нээлт	Сургалт, оюутны хөгжил эрхэлсэн проректор Д.Заяабаатар үг хэлнэ, МУИС-ийн захиргаа, бүрэлдэхүүн сургуулийн захирал нар оролцоно	13:00
6	Гоцлол дуу	Бүх салбар сургууль	13:20
7	Ардын болон язгуур урлаг	Бүх салбар сургууль	14:40
8	Хамтлаг бүжиг чөлөөт	Бүх салбар сургууль	15:20
9	Шагнал гардуулах ёслол	Үзүүлбэр тус бүрээр шагналт байруудыг шагнах, шилдэг сургуулийг шалгаруулна	16:40
10	Хаалт	Хаалтын үг, урлагийн их наадамд оролцогчид зураг даруулна	17:00

Хөтөлбөр: Урлагийн наадам нь нийт 6 төрлөөр явагдана. Үүнд:

- **Мэндчилгээ** /3-5 минут/
- 1. **Гоцлол эсвэл хоршил хөгжим:** /3-5 минут/
- 2. **Хамтлаг бүжиг:** /цэнгээнт бүжиг 5 минутаас ихгүй байх, 8 хос 16 гишүүнтэй байх/
- 3. **Гоцлол дуу** /3-5 минут сонгодог, эстрад, бусад/
- 4. **Ардын болон язгуур урлаг** /3-5 минут хөөмий, исгэрээ, бие биелгээ, магтаал, тууль гэх мэт язгуур үзүүлбэрүүд байх багууд 10-с илүүгүй оролцогчтой байх/
- 5. **Хамтлаг бүжиг чөлөөт** /4-6 минут, багийн нийт гишүүд 15-аас илүүгүй оролцогчтой байна.

Шалгуур үзүүлэлт:

- Ур чадвар
- Бэлтгэл, бичлэг болон хөгжмийн зэмсэг, ая шаардлага хангасан байдал
- Тайзны соёл, хувцаслалт
- Бэлтгэл зохион байгуулалт, найруулга агуулга сайн байх

Тавигдах шаардлага:

- МУИС-ийн оюутан байх
- Салбар сургуулийн “Оюутны зөвлөл”-дөө оролцох төрөл үзүүлбэрээ урьдчилан мэдэгдэж бүртгүүлсэн байх
- Удирдамж заасан дагуу хугацаа, ая, хөгжим, хувцас тайзны жижиг хэрэгсэл бусад бэлтгэлээ урьдчилан хангасан байх
- Үзүүлбэр тодорхой, ойлгомжтой тоглолтын ерөнхий зохиомжид нийцсэн байх
- Урлагийн тоглолт үзүүлбэрийн үед шүүгчид, бусад оролцогчид, хамт олноо хүндэтгэн оролцох
- Үзүүлбэр эхлэхээс өмнө багийн бэлтгэлийг хангаж байраа эзэлсэн байх
- Багууд мэдүүлгийнхээ дагуу оролцох

Дүгнэх, шалгаруулах журам:

- Урлагийн наадмыг мэргэжлийн шүүгчид дүгнэж шалгаруулна
- Оноог нийтэд ил тод нээлттэй өргөж танилцуулах бөгөөд шүүгч тус бүр 1-5.5 оноогоор дүгнэнэ
- Үзүүлбэр тус бүрд тайзны соёл, хувцаслалт баг хамт олны зохион байгуулалт зэргийг харгалзан үзэж дүгнэнэ
- Үзүүлбэр тус бүрийг заасан хугацаанд явагдаж байгаа эсэхэд хяналт тавих хөндлөнгийн шүүгч ажиллах бөгөөд хугацаа хэтэрсэн тохиолдолд 0,5 оноог үзүүлбэрээс хасаж дүгнэх
- Шилдэг үзүүлбэр тус бүр 1, 2, 3 дугаар байр эзлүүлэх ба үзүүлбэр тус бүрийн тэргүүн байрыг мөнгөн шагнал дагалдана
- Шилдэг багаар 1, 2, 3 дугаар байрт шалгаруулж өргөмжлөл мөнгөн шагнал гардуулна

Боловсруулсан:



- Оюутны хөгжлийн газрын
мэргэжилтэн А.Пагамсүрэн

Хянасан:



Сургалт, оюутны хөгжил эрхэлсэн
проректор Д.Заяабаатар